

**ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН  
ТУШААЛД ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 2 дугаар зүйлийг үндэслэн **Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын “Прогресс” сургуулийн захирлын, Дарви сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын, Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын, Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын, Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг нийтэд зарлаж байна.**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу зохион байгуулж явуулна.

**Нэг. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх иргэнд тавигдах болзол**

- Монгол Улсын иргэн байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан байх.

**Хоёр. Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага**

|                  |   |
|------------------|---|
| <b>Боловсрол</b> | Дээд боловсролтой, бакалаврын зэрэгтэй байх   |
| <b>Мэргэжил</b>  | Багш мэргэжил эзэмшсэн байх   |
| <b>Мэргэшил</b>  | Боловсрол, нийгэм, төрийн удирдлага, боловсрол судлалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх  |
| <b>Туршлага</b>  | <ul style="list-style-type: none"><li>• Ерөнхий боловсролын сургуульд үндсэн орон тоонд 5-аас доошгүй жил багшилсан байх;</li><li>• 3-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуульд удирдах албан тушаалд эсхүл боловсролын салбарын байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажилласан байх</li></ul>  |
| <b>Ур чадвар</b> | Багаар ажиллах, багийг удирдан зохион байгуулах чадвар: <ul style="list-style-type: none"><li>- Байгууллагын зорилго, зорилтод хамт олныг нэгтгэх;</li><li>- Байгууллагын хөгжлийг төлөвлөх, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх</li><li>- Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх</li><li>- Албан хаагчдын оролцоог тэгш хангах;</li><li>- Албан хаагч нарыг сэдэлжүүлэх, урам зориг өгөх;</li></ul> |
|                  | Асуудал шийдвэрлэх чадвар: <ul style="list-style-type: none"><li>- Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах;</li><li>- Шийдвэрийн үр дагаврыг урьдчилан тооцоолох;</li><li>- Гаргасан шийдвэрийн үр дагаврыг хариуцах;</li><li>- Маргаан, саналын зөрүүг байгууллагын зорилго, оролцогч талуудын нийцэл, ойлголцол, оролцоог хангаж шийдвэрлэх ;</li></ul>  |
|                  | Манлайлах чадвар: <ul style="list-style-type: none"><li>- Ёс зүйгээр бусдыг үлгэрлэх;</li><li>- Бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч байх;</li><li>- Ажлын шинэ арга барилыг нэвтрүүлэх, хөгжүүлэх;</li></ul>  |

|  |  |
|--|--|
|  | <ul style="list-style-type: none"> <li>- Харилцаа, хандлага, хувийн зохион байгуулалтаар үлгэр дууриал үзүүлэх;</li> <li>- Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд өөрөө үлгэрлэн, манлайлах;</li> </ul> |
|--|--|

### **Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг**

- Төрийн албан хаагчийн анкет “А хэсэг” болон “Б хэсэг”
- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;
- Сонгон шалгаруулалт зарласан албан тушаалд хамаарах байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл /Битүүмжилсэн байна/;
- Иргэний үнэмлэхний хуулбар эх хувийн хамт;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эх хувийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт; /Гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын газраар Монгол хэл дээр хөрвүүлсэн байх/
- Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан бол гэрчлэх баримт бичгийн эх хувийг хуулбарын хамт;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, эх хувийн хамт /ажилласан жилийг тооцох тул хөдөлмөрийн үйл ажиллагаагаа хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн он, сар, өдрөөр нь нарийвчлан бичиж бэлтгэж ирэх/,
- 4 x 6-ийн хэмжээтэй 2 хувь цээж зураг /1 ш нь анкет дээр наагдсан байх/;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд нотлогдох баримт;
- Шалгалтын үйлчилгээний зардал

### **Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах ба бүртгэх**

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт болон бүрдүүлсэн баримт бичгийг Ховд аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 102 тоотд **2020 оны 01 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд** 08:00-16:30 цагийн хооронд хүлээн авна.

### **Тав. Сонгон шалгаруулалтын хуваарь**

**2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 09:00 цагт** сонгон шалгаруулалт эхлэх бөгөөд төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн №25 дугаар тогтоолын сонгон шалгаруулалтын агуулга, хэлбэр, үнэлгээгээр зохион байгуулна.

1. Оролцогчид албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж буй байдлын үнэлгээ;
2. Тухайн салбар, албан тушаалд хамрагдах хууль, эрх зүйн мэдлэг;
3. Дүн шинжилгээ хийх чадвар;
4. Асуудал шийдвэрлэх чадвар;
5. Монгол хэлний бичгийн чадвар, Цахим орчин, компьютерын хэрэглээний програм ашиглах чадвар;
6. Удирдан зохион байгуулах чадвар;
7. Манлайлах чадвар;
8. Багаар ажиллах чадвар.

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцох иргэн “Иргэний цахим үнэмлэх”-ээ үзүүлж шалгалт өгнө.